

ЭМ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэл үндэслэл

1.1. Эм зүйн шинжлэх ухаан сургуулийн харьяа “Оюутны зөвлөл” гэж нэрлэнэ.

1.2. Энэ дүрмийн зорилт нь Оюутны зөвлөлийн зорилго үйл ажиллагааны үндсэн чиглэл, бүтэц зохион байгуулалт, эрх үүрэг, хүлээх хариуцлагийг тодорхойлолт зарцуулахад оршино.

1.3. Оюутны зөвлөлийн өөрийн нийт сургуулийн нийт оюутнуудын хүсэл сонирхол , эрх ашигт тулгуурлан, сургуулийн захиргаа болон нам эвслээс хараат бус, өөрийгөө удирдах ашгийн төлөө бус, оюутнууддаа үйлчилдэг олон нийтийн байгууллага мөн.

1.4. Оюутны зөвлөл нь Монгол улсын үндсэн хууль, ТББ тухай хууль сургуулийн дотоод журам түүнтэй нийцүүлэх гаргасан хууль тогтоомж, Оюутны зөвлөлийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

Хоёр. Оюутны зөвлөлийн эрхэм зорилго:

Оюутны эрх ашгийг хамгаалж, тэднийг төлөвшүүлэн, хөгжүүлэхэд оршино.

Гурав. Оюутны зөвлөлийн зорилго:

Оюутны зөвлөл нь тус салбарын нийт оюутнуудын төлөөлөл байх ба оюутнуудыг сургуулийн удирдлагатай холбох гүүр болж оюутны дуу хоолой, хүсэл тэмүүлэл, бодол санааг хүргэх зорилготой.

Дөрөв. Оюутны зөвлөлийн үйл ажиллагаа үндсэн чиглэл:

4.1. Оюутны зөвлөлийн энэхүү дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхийн тулд доор дурдсан үйл ажиллагааг дангаар буюу салбарын захиргаатай хамтран явуулна.

4.2. Оюутны зөвлөл нь оюутнуудынхаа эрх ашиг төлөөлөн хамгаалах бүтээлч идэвх өрнүүлэх авьяас билэг болон мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд тусална.

4.3. Оюутны эрх ашгийг төлөөлөн хамгаалах, оюутан нэр төр, шударга ёсыг эрхэмлэн хүндэтгэж тэгш байх зарчмаар ажиллана.

4.4. Оюутны эрдэм шинжилгээ судалгааны ажилд тус дөхөм үзүүлж, авьяас боловсрол мэдлэгийг тодруулах цаашид хөгжихөд нь тусална.

4.5. Оюутан багш сургууль гурвын холбоог бэхжүүлэх

4.6. Оюутнуудаа бусад сургуулийн оюутнуудтай харилцах, санал бодол, мэдээлэл чөлөөтэй солилцох бүх талын бололцоог бүрдүүлэх тэдгээрийн хамтын үйл ажиллагааг дэмжинэ.

Тав. Бүтэц зохион байгуулалт

5.1. Оюутны зөвлөл нь зохион байгуулалтын хувьд оюутнуудын нэгтгэж зөвлөлийн зарчмаар ажиллана.

5.2. Гишүүнчлэлийн асуудлыг нийт зөвлөлийн гишүүдийн санал асуулгаар шийднэ.

5.3. Оюутны зөвлөлийн гишүүд сургуулийн оюутнуудаас бүрдэнэ.

5.4. Оюутны зөвлөлийн бүтэц

5.4.1. Гадаад харилцаа хариуцсан

5.4.2. Дотоод харилцаа хариуцсан

Зургаа. Гишүүнчлэл

6.1. Оюутны зөвлөлийн дарга

6.1.1. Оюутны зөвлөлийн дарга оюутан байна.

6.1.2. Оюутны зөвлөлийн даргыг нийт оюутнуудын санал асуулгаар сонгох

6.1.3. Оюутны зөвлөлийн дарга нь нийт оюутнуудыг эв нэгдлийг илэрхийлэгч мөн.

6.1.4. Оюутны зөвлөлийн дарга нь нийт оюутнуудын нийтлэг эрх ашиг сонирхолыг төлөөлөн хамгаалах, захиргаа аж ахуйн хэмжээнд оюутны эрхийн талаарх баримтлах бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд төлөөлөн оролцоно.

Долоо. Нарийн бичиг

7.1. Оюутны зөвлөлийн дарга ажилд нь томилно.

7.2. Оюутны зөвлөлийн бүх гишүүдийн саналаар сонгоно.

Найм.Оюутны зөвлөлийн бүрэн эрх:

8.1. Оюутны зөвлөлийн хурал 7 хоног 1 удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдаан зарлан хуралдуулна.

8.2. Хурлаар дараах асуудлыг шийднэ.

8.2.1. Оюутны зөвлөлөөс зохион байгуулсан ажлын үр дүнг хэлэлцэх

8.2.2. Салбар секторуудын ажлыг тус бүрд нь хэлэлцүүлэх.

8.2.3. Оюутны зөвлөлийн дарга болон гишүүдийг сонгох чөлөөлөх.

8.2.4. Оюутны зөвлөлийн дүрэм,бүтэц зохион байгуулалт үйл ажилгаанд нэмэлт өөрчлөлт оруулах

Ёс. Оюутны зөвлөлийн үүрэг:

9.1. Дүрэмд заасан үйл ажилгааг ойрын ба хэтийн төсөл,хөтөлбөр,төлөвлөгөөний дагуу явуулах.

9.1.1. Хариуцсан секторын ажлын /хичээлийн жилээр/ төлөвлөгөөг хичээлийн жилийн эхний сард багтаан төлөвлөж, Оюутны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, оюутны албатай зөвлөлдсөний дараа батлуулна.

9.1.2. Төлөвлөсөн ажлаа цаг хугацаанд нь чадварлаг зохион байгуулж, Оюутны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үнэлгээ авна.

9.1.3. Төлөвлөсөн ажлаа цаг хугацаанд нь гүйцэтгээгүй, цалгардуулсан, муу зохион байгуулсан дарга, гишүүдийн урамшуулалыг хасах буюу онцгой тохиолдолд урд нь олгосон урамшуулалыг оюутны зөвлөл буцаан төлнө.

9.2. Мэргэжлийн сургуулиудын хооронд зохиогдох урлаг спорт,соёл хүмүүжлийн үйл ажиллагаа болон хурал зөвлөгөөн,семинар зохион байгуулах.

9.3. Оюутны мэдлэгийг дээшлүүлэх, практикийн дадлагыг сайжруулах шаардлагатай үед оюутнуудын эрхийг хамгаалах ажилд оролцоно.

9.4. Төлөвлөгөөт жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг ажлыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу оюутны алба, санхүүтэй хамтран зохион байгуулдаг.